



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.04.06

№ 14

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “...Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, жилийн 4-6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулна...” гэж заасан.

Энэ хүрээнд “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д өөрчлөлт орж, 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө авсан зээлийн жилийн хүүг 8 хувь, 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн авч буй зээлийн жилийн хүүг 6 хувь байхаар тогтоосон билээ.

Үүнтэй холбоотойгоор орон сууцны ипотекийн 8 хувийн зээлийн хүүгээ бууруулж, 6 хувийн хүүтэй болгох хүсэлтэй иргэн маш олон байна. Цар тахлын дэгдэлтээс үүдсэн эдийн засгийн хямралаас шалтгаалан иргэдийн орлого буурч байгаа тул ипотекийн зээлийн хүүг өмнө болон дараа авсан гэж ялгалгүйгээр 6 хувь болгон тэгшитгэн бууруулах нь зүйтэй гэж үзэж байгаа болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1–т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд орон сууцны ипотекийн зээлийн хүү бууруулахтай холбоотой дараах асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар орон сууцны ипотекийн 8 хувийн хүүтэй зээлд хамрагдсан хэчнээн иргэн байгаа, тэдний ипотекийн зээлийн хүүг 8-аас 6 хувь болгон бууруулахад хэдий хэмжээний төсөв санхүү шаардагдах талаар;
2. Ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийг цаашид урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх эдийн засгийн бодит боломж хэр байгаа талаар;
3. Ипотекийн зээлийн хүү буурч, орон сууцны эрэлт өссөнтэй холбоотойгоор барилгын компаниуд үнийн зохиомол хөөрөгдөл үүсгэхгүй байх тал дээр ямар бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар;
4. Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн үндсэн болон хүүний төлбөрийг хойшлуулахаар хэчнээн иргэн хандсан, арилжааны

2020000147